МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

JOINT SDG FUND

Олон улсын хөдөлмөрийн байгууллага

НҮБ-ын “Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд хариу үзүүлэх бэлэн байдлыг нэмэгдүүлэх нь” Хамтарсан хөтөлбөр (2020-2022)

# МАЛЧДЫН НИЙГМИЙН ДААТГАЛ

(Малчдад зориулсан гарын авлага)



**2020 он**

# АГУУЛГА

## 1 МАЛЧНЫ НИЙГМИЙН ДААТГАЛ

- Малчин гэр бүл
- Нийгмийн даатгал
- Өндөр насны тэтгэвэр
- Малчин даатгуулагч
- Сайн дурын даатгал
- Тэтгэмж
- Малчны тэтгэвэр

## 2 МАЛЧДЫН ХОРШОО

- Хоршооны гишүүн
- Хоршооны тухай хууль
- Хоршооны мөн чанар
- Хоршооны зарчим
- Малчдын хоршоо
- Хоршооны хөрөнгө
- Таван хошуу мал

## 3 ТОГТВОРТОЙ МАЛ АЖ АХУЙ

- Малчин гэр бүл
- Тогтвортой Аж ахуй
- Цочролыг даван туулах
- Тогтвортой Нийгэм
- Тогтвортой Эдийн засаг
- Тогтвортой Байгаль орчин
- Таван хошуу мал

# НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ



## Даатгал гэж юу вэ?

Хүний амьдралд учирч болзошгүй тааламжгүй үйл явдлын эрсдлийг бууруулах, учирч болох хохирлыг хамгийн богино хугацаанд арилгах үр дүнтэй санхүүгийн арга хэрэгсэл нь даатгал юм.

## Нийгмийн даатгал гэж юу вэ?

Иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх зэрэг гэнэт бий болсон эрсдлийг бууруулах, давж гарахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий нийгэм эдийн засгийн харилцааг зохицуулсан үйлчилгээ юм.

## Нийгмийн даатгалын хэлбэр

### АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

АЖИЛТАН

- ААН байгууллага
- Төрийн бус байгууллага
- Шашны болон бусад байгууллага
- Хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж буй МУ-ын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн
- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын ААН
- Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр
- Гадаад орны дипломат төлөөлөгчийн газар
- Олон улсын байгууллагад ажиллаж буй Монгол улсын иргэн, гадаадын иргэн харьяалалгүй хүн
- Төрийн албан хаагч

### САЙН ДУРЫН ДААТГАЛ

ТОДОРХОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЭГҮЙ

- Бичил уурхай эрхлэгч
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч
- **Малчин**
- Газар тариалан эрхлэгч
- Чөлөөт уран бүтээлч
- Гадаад улсад ажиллаж, амьдарч буй иргэн
- Оюутан
- Тодорхой ажил эрхлээгүй иргэн

## Нийгмийн даатгалын төрөл, хэлбэр



- **Тэтгэврийн**
- **Тэтгэмжийн**
- **Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ)**
- **Эрүүл мэндийн**
- **Ажилгүйдлийн**

## Нийгмийн даатгалын сангууд



### Тэтгэврийн даатгалын сан

- Өндөр насны тэтгэвэр
- Тахир дутуугийн тэтгэвэр
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр

### Тэтгэмжийн даатгалын сан

- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
- Жирэмсэн болон амаржсаны тэтгэмж
- Оршуулгын тэтгэмж

### ҮОМШӨ-ний даатгалын сан

- Тахир дутуугийн тэтгэвэр
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
- Хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбоотой төлбөр, зардал

### Ажилгүйдлийн даатгалын сан

- Ажилгүйдлийн тэтгэмж
- Сургалтын зардал

# Сайн дурын даатгал

**Орлого тодорхойлох**

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ



10 дахин нэмэгдүүлсэн байж болно

2021 он **420,000₮** (Орлогын хэмжээ)

14,5% **60,900₮** (Сар бүр төлнө)






- Сайн дурын даатгалын шимтгэлийн нийт хувь
- Тэтгэврийн даатгалын хувь хэмжээ
- Тэтгэмжийн даатгалын хувь хэмжээ
- ҮОМШӨ-ний даатгалын хувь, хэмжээ

## Гэрээ байгуулах, шимтгэл төлөх

Оршин суугаа аймаг, сум дүүргийнхээ нийгмийн даатгалын байгууллага /хэлтэс, байцаагч/-д цахимаар, эсхүл биечлэн хандаж нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах хүсэлтээ гаргаж гэрээ байгуулна.

## Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах гэрээ байгуулахад анхаарах зүйлс

**Бүрдүүлэх бичиг баримт**

- Иргэний үнэмлэх
- Нийгмийн даатгалын дэвтэр

**Гэрээ байгуулахдаа:**

- Шимтгэл төлөх орлогоо мэдүүлнэ
- Шимтгэл төлөх хугацааг тохирно. (сар, улирал, жил)
- Нэг сараас доошгүй хугацааны шимтгэл төлнө.
- Гэрээний хугацааг сунгах хүсэлтээ гэрээний хугацаа дуусахаас өмнө гаргана.

**Шимтгэл төлөхдөө:**

- Шимтгэл төлсөн огноо, гэрээ байгуулсан огноо ижил байна.
- Гэрээнд заасан хугацаанд тогтмол төлнө.
- НД-ын дэвтрээ байцаагчид авчирч шимтгэл төлөлтөө баталгаажуулна.

**Гэрээг хүчингүйд тооцох, дуусгавар болох**

Гэрээ хүчингүй болох

- Шимтгэлийг нөхөж төлсөн
- Гэрээнд зайлшгүй тусгагдах заалтуудыг бүрэн тусгаагүй
- Гэрээ байгуулсан боловч нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй

Гэрээ дуусгавар болох

- Аж ахуй нэгж, байгууллагад ажилд орох
- Нас барсан
- Тэтгэвэр тогтоолгосон
- Даатгуулагч өөрөө хүсэлт гаргасан

## Өндөр насны тэтгэвэр



**50 нас**
хүрсэн бол

**10 жил**
газрын дор
ажилласан бол

**10 жил**
хөдөлмөрийн хортой,
халуун нөхцөлд
ажилласан бол

**55 нас**
хүрсэн бол

**12 жил**
хөдөлмөрийн хүнд
нөхцөлд ажилласан бол

**15 жил**
малчнаар ажилласан бол

Нийтдээ 20-иос
доошгүй жил шимтгэл
төлсөн эрэгтэй

**Эрэгтэй даатгуулагч**



**45 нас**
хүрсэн бол

**7 жил 6 сар**
хөдөлмөрийн хортой,
халуун нөхцөлд
ажилласан бол

Нийтдээ 20-иос
доошгүй жил шимтгэл
төлсөн эмэгтэй

**50 нас**
хүрсэн бол

4 ба түүнээс дээш
хүүхэдтэй бол

**10 жил**
хөдөлмөрийн хүнд
нөхцөлд ажилласан бол

**12 жил 6 сар**
малчнаар ажилласан бол

**Эмэгтэй даатгуулагч**

## Бүрэн тэтгэвэр

Бүрэн тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

**Эрэгтэй**
**65**
насанд хүрсэн

**Эмэгтэй**
**65**
насанд хүрсэн

| 2018 | 2019 | 2020 | 2021 |
| --- | --- | --- | --- |
| 20 жил 3 сар | 20 жил 6 сар | 20 жил 9 сар | 21 жил |
| Болзол | | | |

Нийтдээ 25-иос доошгүй жил шимтгэл төлсөн

## Тэтгэврийн хэмжээ бодох аргачлал

**Дундаж цалин хөлс, орлогыг тодорхойлохдоо:**

2021 он

Нийт орлого
**84 сар**

**Дараалсан 7 жил**

Даатгуулагчийн дараалсан 7 жилийн нийт орлогыг 84 сард хувааж өндөр насны тэтгэвэр тогтоохоод баримтлах дундаж цалин хөлс, орлогыг тодорхойлно.

**Тэтгэврийг тогтоохдоо:**

Орлогын дундаж **x 45%**

**45 хувь**

Даатгуулагчийн дараалсан 7 жилд шимтгэл төлсөн орлогын дунджаас 45 хувиар бодож тэтгэвэр тогтооно.

**Нэмэгдэл тооцохдоо:**

Жил - 1.5%
Сар - 0.125%

**20 жилээс илүү төлсөн**

Даатгуулагч шимтгэлээ 20 жилээс илүү төлсөн жил тутамд 1.5%, сар тутамд 0.125%-аар тэтгэвэр тогтоолгосон сарбн дундаж цалин хөлс, орлогоос тооцож нэмэгдэл олгоно.

**Тахир дутуугийн тэтгэврээс өндөр насны тэтгэвэр тогтоолгохдоо:**

Жил тутам **1%**

**Хөдөлмөрийн чадвараа алдсан**

Даатгуулагч шимтгэлээ 20 жилээс илүү төлсөн жил тутамд 1.5%, сар тутамд 0.125%-аар тэтгэвэр тогтоолгосон сарын дундаж цалин хөлс, орлогоос тооцож нэмэгдэл олгоно.

# Малчин даатгуулагчийн талаарх хууль, эрх зүй

## Өндөр насны тэтгэвэр тогтоолгох нөхцөл, болзол

Малчдад өндөр насны тэтгэвэр тогтоох насыг 5 жилээр наашлуулав.

*/2018 оны 1 сарын 1-ээс эхлэн хэрэгжив/*



**Малчин эрэгтэй**

**55 нас**

- Нийтдээ **20-иос доошгүй жил** шимтгэл төлсөн байх
- **15-аас доошгүй жил** малчнаар ажилласан байх

**Малчин эмэгтэй**

**50 нас**

- Нийтдээ **20-иос доошгүй жил** шимтгэл төлсөн байх
- **12 жил 6 сараас доошгүй жил** малчнаар ажилласан байх

Улсын хэмжээнд 2021 оны 3-р сарын 31-ны өдрийн байдлаар 18.5 мянга гаруй малчин даатгуулагчид өндөр насны тэтгэвэр эрт тогтоож 71.4 тэрбум гаруй төгрөгийн тэтгэвэр олгов.

## Малчнаар ажилласан хугацааг тодорхойлох нь

**МАЛЧИН**

Мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог, цаа буга маллаж байсан даатгуулагч, саальчин, 1990 оноос өмнөх хугацаанд тууварчнаар ажиллаж хуульд заасан шимтгэл төлөх нөхцөл болзлыг хангасан даатгуулагч.

**Тэтгэврийн даатгалд даатгуулснаар нөхөн тооцуулсан бол — 1991–1994 он**

- Баталгаажилтын хуудас
- Баг, хорооны Засаг даргын тодорхойлолт

**Даатгуулагчийн 1995 оноос өмнөх ажилласан хугацааг тодорхойлох — 1995 оноос өмнө**

- Хөдөлмөрийн дэвтэр
- ХАА-н нэгдлийн гишүүний хөдөлмөрийн дэвтэр
- Архивын лавлагаа
- Шүүхийн шийдвэр

**Даатгуулагчийн 1995 оноос хойш ажилласан хугацааг тодорхойлох — 1995 оноос хойш**

- 1995 оноос хойш хугацааны нийгмийн даатгалын дэвтэр
- Баталгаажилтын хуудас
- Шимтгэл төлсөн лавлагаа
- "А" дансны лавлагаа

### "А" дансны лавлагаагаар нотлогдохгүй тохиолдолд:

1995 оноос хойш хугацаанд малчнаар ажилласан нь "А" дансны лавлагаагаар нотлогдохгүй тохиолдолд орон тооны бус байнгын зөвлөл тодорхойлно. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сум, дүүргийн Засаг даргын захирамжаар батална.

### Зөвлөлийн бүрэлдэхүүнд:

1. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга
2. Баг (хороо)-ийн Засаг дарга
3. Нийгмийн даатгалын байцаагч (ажилтан), малчны болон малын бүртгэл хариуцсан мал зүйч, малын эмч
4. Нийгмийн ажилтан
5. Улсын бүртгэл болон статистикийн асуудал хариуцсан ажилтан
6. Тухайн сум, баг, хороонд олон жил удирдах албан тушаалд ажиллаж байсан болон олон жил амьдарч байгаа нутгийн уугуул иргэний төлөөлөл



"Малчинд тэтгэвэр тогтоох, тэтгэврийн нас нэмэгдүүлэхэд баримтлах журам"-ыг Засгийн газрын 2018 оны 71 дүгээр тогтоолоор, даатгуулагчийг малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөлийн дүрмийг ХНХС-ын 2018 оны 77 дугаар тушаалаар тус тус батлан мөрдүүлж байна.

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлнэ

/УИХ-ын 2021 оны 01 сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар/

| | |
|---|---|
| 1995–аас 2019 онууд | **Хамрагдах хугацаа** |
| 15–аас 60 настай | **Хамрагдах нас** |
| 2021 оноос: 2021.1.1–ээс – 2021.12.31 | **Хуулийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа** |
| Нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангаас өндөр насны тэтгэвэр, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгоогүй, 1995-2019 онуудад шимтгэл төлөөгүй 15-60 насны Монгол улсын иргэд хамрагдана. | **Хамрах хүрээ** |

## Эхчүүдийн НДШ төлсөн хугацааг нэмэгдүүлэх

Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг төрүүлж өсгөсөн хүүхэд бүрийн тоогоор нэмэгдүүлнэ. **1 ЖИЛ 6 САР**

**2020 онд**

**22,9 мян**
эхчүүд хамрагдаж 1 эхийн тэтгэвэр 7.5%-иар буюу сард 30,000 гариу төгрөгөөр нэмэгдэж нэмэгдэлд

**3,3**
тэрбум төгрөг зарцуулсан.

| Хүүхдийн тоо | Нэмэгдэх хугацаа |
|---|---|
| 1 хүүхэд | 1 жил 6 сар |
| 2 хүүхэд | 3 жил |
| 5 хүүхэд | 7 жил 6 сар |
| 8 хүүхэд | 12 жил |



### 3 нас хүртэл хүүхдээ асарч буй эхчүүд

Хүүхдээ 3 нас хүртэл асрах чөлөөтэй байгаа ээжүүдийн НДШ төлсөн хугацаа тасрахгүй

*/Засгийн газрын 2019 оны 485 дугаар тогтоол/*



**2020 онд**

**17,1 мян**
эхчүүд хамрагдаж

**3,1**
тэрбум төгрөг зарцуулсан.

Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авахаас өмнө

| Нөхцөл | Төлөгч | Хувь |
|---|---|---|
| **ААН, байгууллагад** ажиллаж байсан бол: | Ажил олгогч | **100%** |
| Нийгмийн даатгалд **сайн дураар** даатгуулж байсан бол: | Тэтгэмжийн даатгалын сан | **50%** |
| | Хүүхэд асарч буй эх өөрөө | **50%** |
| Нийгмийн даатгалд **даатгуулж** байгаагүй бол: | Улсын төсвөөс | **50%** |
| | Хүүхэд асарч буй эх өөрөө | **50%** |

# Тэтгэмж тогтоолгох нөхцөл, болзол

## Тэтгэмжийн даатгалын сан

**Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж** — Хөдөлмөрийн чадвараа түр алдахаас өмнө 3 сараас доошгүй хугацаанд шимтгэл төлсөн бол

**Жирэмсэн болон амаржсаны тэтгэмж** — Жирэмсний чөлөө авахаас өмнө нийтдээ 12 сараас доошгүй, сүүлийн 6 сар нь тасралтгүй төлсөн бол

**Оршуулгын тэтгэмж** — Нийтдээ 36 сараас доошгүй хугацаанд шимтгэл төлсөн бол

## Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхцөл, болзол, анхаарах зүйлс

### Нөхцөл Болзол

**Ердийн өвчин, ахуйн ослын улмаас**

Хөдөлмөрийн чадвараа алдахаас өмнө **3 сар,** түүнээс дээш хугацаагаар шимтгэл төлж ажилласан бол

**Хүүхэд**

Хүүхдээ **196 хоног хүртэл** тээгээгүй дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн эмэгтэйчүүд

### Бүрдүүлэх баримт бичиг



Нийгмийн даатгалын дэвтэр



Эмнэлгийн хуудас

### Өргөдөл гаргах хугацаа

**4 долоо хоногийн дотор** Хөдөлмөрийн чадвар алдсанаас хойш. Хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор

Өргөдөл гаргаснаас хойш **21 хоногийн дотор** шийдвэрлэнэ.

### Тэтгэмжийн хэмжээ

Сүүлийн бүтэн ажилласан 3 сарын хөдөлмөрийн хөлсийг ажилласан нийт хоногт хуваах гаргасан дундажаас цалингаас дор дурьдсан хувиар бодож олгоно.

| Шимтгэл төлж ажилласан жил | Тэтгэмж бодох хувь хэмжээ |
|---|---|
| 5 хүртэл | 50% |
| 5-14 | 55% |
| 15 ба түүнээс дээш | 75% |

## Жирэмсний болон амаржсаны тэтгэмж, нөхцөл, болзол, анхаарах зүйлс

Тэтгэмжийг ажлын өдрөөр тооцно.

### Нөхцөл Болзол

Жирэмсний чөлөө авахаас өмнө **12 сараас доошгүй,** үүнээс сүүлийн **6 сард тасралтгүй** шимтгэл төлсөн

**196 хоног тээгээгүй** боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн

### Бүрдүүлэх баримт бичиг



Нийгмийн даатгалын дэвтэр



Эмнэлгийн хуудас

### Өргөдөл гаргах хугацаа

Эмнэлгийн хуудас авснаас хойш **4 долоо хоногийн дотор**

Өргөдөл гаргаснаас хойш **21 хоногийн дотор** шийдвэрлэнэ

### Тэтгэмжийн хэмжээ

Шимтгэл төлсөн сүүлийн **12 сарын** ХХТАО-ын дунджаас 100% бодож **4 сарын** хугацаанд олгоно

### Хууль

Хөдөлмөр эрхэлж байгаад хууль тогтоомжид заасны дагуу хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаанд **дахин хүүхэд төрүүлсэн эхэд** жирэмсний болон амаржсаны **тэтгэмж олгоно.**

Жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг жирэмсний амралт эхэлснээс хойш болон амаржсан өдрөөс хойш **30 хоногийн** дотор эмнэлгийн хуудсыг олгоно.

## Оршуулгын тэтгэмж, нөхцөл, болзол, анхаарах зүйлс

### Нөхцөл Болзол

**Ердийн өвчин, ахуйн ослын улмаас**

**36 сараас доошгүй,** хугацаагаар шимтгэл төлсөн

**ҮОМШӨ-ний улмаас**

Шимтгэл төлсөн хугацаа харгалзахгүй

**Тэтгэвэр, тэтгэмж**

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авч байсан бол

### Бүрдүүлэх баримт бичиг

Өргөдөл

Нас барсны гэрчилгээ



Нийгмийн даатгалын дэвтэр (Хөдөлмөрийн дэвтэр)



Тэтгэврийн дэвтэр

### Өргөдөл гаргах хугацаа

**4 долоо хоногийн дотор** хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор

Өргөдөл гаргаснаас хойш **21 хоногийн дотор** шийдвэрлэнэ.

### Тэтгэмжийн хэмжээ

**1,000,000 төгрөг** /НДҮЗ-ийн 2016 оны 16 дугаар тогтоол/

**Сайн дурын даатгуулагч та нийгмийн даатгалын шимтгэлээ дараах байдлаар тооцоорой.**

| *0-3 насны хүүхдээ асарч буй сайн дурын даатгуулагч эхийн өөрөө мэдүүлсэн сарын орлого* | *Шимтгэл тооцох хувь хэмжээ* | *Төлбөл зохих НДШ* | *2021.07.01 хүртэл* | |
|---|---|---|---|---|
| | | | *Өөрөө хариуцан төлөх* | *Чөлөөлөгдөх дүн* |
| 420,000 | **14,5%** | 60,900 | 35,700 | **25,200** |
| 600,000 | | 87,000 | 61,800 | |
| 1,000,000 | | 145,000 | 119,800 | |
| 4,200,000 | | 609,000 | 583,800 | |

| *0-3 насны хүүхдээ асарч буй сайн дурын даатгуулагч эхийн өөрөө мэдүүлсэн сарын орлого* | *Шимтгэл тооцох хувь хэмжээ* | *Төлбөл зохих НДШ* | *2021.07.01 хүртэл* | |
|---|---|---|---|---|
| | | | *Өөрөө хариуцан төлөх* | *Чөлөөлөгдөх дүн* |
| 420,000 | **13,5%** | 56,700 | 26,250 | **30,450** |
| 600,000 | **14,5%** | 87,000 | 52,350 | **34,650** |
| 1,000,000 | | 145,000 | 110,350 | |
| 4,200,000 | | 609,000 | 574,350 | |

Сарын шимтгэлээ төлснөөр таны гэрээ өмнөх гэрээний хугацаагаар сунгагдана.

Банкны цахим үйлчилгээ /интернет банк, мобайл банк, Qpay/-г ашиглан шимтгэлээ төлөөрэй.

“Нийгмийн даатгал” гар утасны аппликейшнээр шимтгэлийн тооцооллоо хялбар хийж, гэрээгээ сунган, төлбөр төлөх банкны системд шууд холбогдох боломжтой

# МАЛЧДЫН ХОРШОО

Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд **сайн дураараа нэгдсэн, ардчилсан, хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө** дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээдийг **ХОРШОО** гэнэ.

## Хоршооны мөн чанар

- Хоршоог гишүүд сайн дураараа байгуулна.
- Хоршоонд гишүүд сайн дураараа элсэнэ.
- Хоршоог гишүүд өөрсдөө эзэмшиж өмчилнө.
- Хоршооны үр шимийг гишүүд өөрсдөө хүртэнэ.
- Хоршоог гишүүд өөрсдөө удирдана.
- Хоршооны үйлчилгээг гишүүд өөрсдөө авна.



*Хоршооны гишүүд*

**Хоршооны гишүүн өөрөө**

- ☑ ӨМЧЛӨГЧ
- ☑ ХЭРЭГЛЭГЧ
- ☑ АЖИЛЛАГЧ
- ☑ ҮЙЛДВЭРЛЭГЧ
- ☑ УДИРДАГЧ
- ☑ ХЯНАГЧ
- ☑ АШИГ ХҮРТЭГЧ

## Хоршооллын 7 зарчим

1. САЙН ДУРЫН НЭЭЛТТЭЙ ГИШҮҮНЧЛЭЛ
2. ГИШҮҮДИЙН АРДЧИЛСАН ХЯНАЛТ
3. ГИШҮҮДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ОРОЛЦОО
4. БИЕ ДААСАН БАЙДАЛ
5. БОЛОВСРОЛ СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ
6. ХОРШООДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА
7. НИЙТИЙН САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ

## Хоршооны бүтэц




## Хоршооны хөрөнгө бүрдүүлэлт






**хувь хөрөнгийн дээд, доод хэмжээ**

Хоршооны гишүүдээс оруулсан хувь хөрөнгийн дээд, доод хэмжээг заавал тогтоох ба энэ хөрөнгийг нийлүүлснээр **жинхэнэ гишүүний** эрх үүснэ.



## Хоршооны гишүүн, түүний эрх, үүрэг

Тухайн хоршооны дүрмийг зөвшөөрч сайн дураараа хоршоонд элссэн, түүний үйлчилгээг авч, холбогдох хариуцлагыг хүлээх чадвартай 16-аас дээш насны иргэн хоршооны гишүүн байна.

### Хоршооны гишүүний эрх



Хоршооны тухай хууль



14.1-р заалт

- 14.1.1 Дүрэмд заасны дагуу хоршооноос зохих үйлчилгээ авах
- 14.1.2 Өөрийн хүсэлтээр хоршооноос гарах, дахин элсэх
- 14.1.3 Хоршооны үйл ажиллагаанд оролцож, Тэргүүлэгч, хяналтын зөвлөлийг сонгох, сонгогдох
- 14.1.4 Бүх гишүүдийн хуралд оролцож санал тавих, санал гаргах, шийдвэр гаргахад таслах эрхтэй оролцох
- 14.1.5 Бүх гишүүдийн ээлжит бус хурал хуралдуулах санал гаргах
- 14.1.6 Тогтоосон журмын дагуу ногдол ашиг-хувь хүртэх
- 14.1.7 Жилийн тайланг бүх гишүүдийн хурлаар батлахаас өмнө ХЗ-ийн дүгнэлтийг шаардаж авах
- 14.1.8 Бүх гишүүдийн хурлын тэмдэглэлтэй танилцах
- 14.1.9 Хоршооны гишүүдийн бүртгэлтэй танилцах
- 14.1.10 Хууль дүрэмд заасан бусад эрх
- 14.1.11 Хууль, дүрэмд өөрөөр заагаагүй бол өрсөлдөгч бус өөр хоршоонд гишүүн байх, хуулийн этгээдийн хувь нийлүүлэгч байх

### Хоршооны гишүүний үүрэг

- 15.1.1 Хоршооны үйл ажиллагаанд оролцох
- 15.1.2 Хоршооны тухай хууль болон хоршооны дүрэм, БГХ-ын шийдвэрийг дагаж мөрдөх, хоршоонд оруулах хувь хөрөнгөө хугацаанд нь бүрэн нийлүүлэх
- 15.1.3 Хоршооны болон бусад гишүүдийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх
- 15.1.4 Оршин суугаа хаягаа өөрчилсөн бол цаг тухайд нь хоршоонд мэдэгдэж байх
- 15.1.5 Хууль, дүрэмд заасан бусад үүрэг

# ТОГТВОРТОЙ МАЛ АЖ АХУЙ




**ТОГТВОРТОЙ БАЙДАЛ**

**Нийгмийн тогтвортой байдал**
- Хууль журам
- Бодлого шийдвэр
- Нийгмийн хамгаалал

**Байгаль орчны тогтвортой байдал**
- Бэлчээр, хадлан
- Отрын нөөц
- Хужир, ус
- Зэрлэг амьтан

**Эдийн засгийн тогтвортой байдал**
- Үнэ ханш
- Зах зээл
- Түншлэл
- Гэрээ хэлцэл

## Тогтвортой аж ахуй эрхлэгч гэж хэн бэ?

- Аж ахуй эрхлэх шинэ мэдлэг мэдээлэл, туршлага суралцдаг үйлдвэрлэгч өрх
- Эрүүл малтай, ариутгал халдваргүйтлийг тогтмол хийлгэдэг
- Байгалийн эрсдэл, гамшгаас урьдчилан сэргийлдэг
- Орон нутагтаа зохицсон ашиг шимтэй малтай
- Байгалийн нөөцийг ариглан гамнадаг



- Дэлхийн зах зээлийн шаардлагын дагуу түүхий эдээ бэлтгэдэг, байнгын найдвартай түншлэгч
- Нийгмийн даатгалаа төлдөг
- Өөрийн болон өрхийн гишүүдийн эрүүл, аюулгүй байдлыг хангадаг
- Хамтарч, хоршиж ажилладаг
- Бэлчээрээ хуваарьтай ашигладаг

Статистик

**ДНБ-ний 24.1% ХАА-н салбараас**



**Нийт хүн амын 31.5% хөдөө амьдардаг**



## Малчны халааг тогтвортой байлгахад чиглэсэн гурамсан холбоо

Залуу малчдын нутгийнхаа нийгмийн хөгжилд гүйцэтгэж буй үүрэг оролцоог нэмэгдүүлэх, амжиргаагаа хөтлөн авч явах боломжийг нэмэгдүүлэх хэрэгцээг хангах.

**ШИНЭ ЦАГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

**ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ**

**МАЛ МАЛЛАГАА, НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ**

- Зохион байгуулалт
- Манлайлал
- Хариуцлага

- Мэдээлэл түгээх
- Шинэ мэдлэг чадвар үүсэх

- Нийгмийн капитал бүрдэх
- Шинэлэг санал санаачлага



## Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг дэмжих төлөвлөгөө

**Төлөвлөгөөний зорилго**

Бэлчээрийн тогтвортой менежмент бүхий эдийн засгийн үр ашигтай, хүнсний аюулгүй байдал, нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг сайжируулсан бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангасан Монгол Улсын мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг дэмжих

**Хамрах хүрээ, Үндсэн зарчим**

1. Бэлчээрийн тогтвортой менежмэнтийг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох
2. Мал аж ахуйн салбарын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх
3. Малын эрүүл мэнд, хүнсний хангамж
4. Хөдөөгийн нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулах
5. Хамтын ажиллагаа, оролцоог дээшлүүлэх




| Малын төрөл | 2015 он | 2016 он | 2017 он | 2018 он | 2019 он |
|---|---|---|---|---|---|
| Бүгд | 55,979 | 61,549 | 66,219 | 66,460 | 70,969 |
| Адуу | 3,295 | 3,635 | 3,940 | 3,940 | 4,215 |
| Үхэр | 3,780 | 4,080 | 4,388 | 4,380 | 4,753 |
| Тэмээ | 0,367 | 0,401 | 0,434 | 0,460 | 0,472 |
| Хонь | 24,943 | 27,856 | 30,110 | 30,554 | 32,267 |
| Ямаа | 23,593 | 25,575 | 27,347 | 27,124 | 29,262 |









## ЭХ БЭЛТГЭЛ, ИНФОГРАФИК ДИЗАЙН

Center For Competency Based Education

“Чадамжид суурилсан боловсролыг дэмжих төв” ТББ-д бэлтгэв.

cbe.union2018@gmail.com
www.cbe.mn